



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2009 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

Тэтгэлэг олгох тухай

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Унгар Улсын Боловсролын яам, Үндэсний соёлын өвийн яам хооронд байгуулсан Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор батлагдсан” Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох тухай журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Унгар Улсын Боловсролын яам, Үндэсний соёлын өвийн яам хооронд байгуулсан Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай төлөвлөгөөний дагуу Бүгд Найрамдах Унгар Улсын их, дээд сургуульд 2009-2010 оны хичээлийн жилээс тэтгэлэггүйгээр суралцах Өлзийдэмбэрэл овогтой Ирэхзаяа, Цэдэн-Иш овогтой Энхтүвшин, Цолмонгэрэл овогтой Хурцбаатар нарт Сургалтын төрийн сангаас амьжиргааны тэтгэлгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор батлагдсан” Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох тухай журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2009 оны 451/318 дугаар хамтарсан тушаалын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР